



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А649

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 ээлжит 5 дугаар хуралдааны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймагт 2018 оны 12 сарын 10,11-ний өдрүүдэд “Нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь” төслийн үйл ажиллагаатай танилцаж ажилласан Дэлхийн банк, Швейцарийн хөгжлийн агентлагын төлөөлөгчдийг хүлээн авсан зардлыг 1722900 (Нэг сая долоон зуун хорин хоёр мянга есөн зуу) төгрөгөөр тогтоосугай.

2. Дээрх зардлыг “Найрсаг Хөвсгөл” дэд хөтөлбөрийн зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (З.Отгонбаяр), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Сувд)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга (Х.Цэнд-Аюуш)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД